АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Архангай аймгийн Эрдэнэбулган сумын Лаборатори нэгдүгээр сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: АРА-2022/165/НА-СТА-ТШЗ**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Архангай аймаг<br>2022 он | Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа<br>Утас:7033-3141<br>Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn<br><br>Аудитын менежер Д.Нэргүйбаатар<br>Утас: 7033-2860<br>Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn<br><br>Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн:<br>Гэрэлт хөхийн тэнцвэр аудит ХХК<br>Утас: 99099119<br>Цахим хаяг: gerelthuhaudit@gmail.com |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**Агуулга**

1.Аудитын санал дүгнэлт

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан....................................4

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ..............................................................4

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ............................................................5

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ..........................................7

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан...................................................................8

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ..............................................................10

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.................................................13

3. Аудитын тайлан.........................................................................................................14

**3.1 Ерөнхий зүйл**............................................................................................14

**3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт** ..................................................14

**3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал** ........................................................15

**3.4 Материаллаг байдал** ......................................................................................15

**3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга** ....................................................................15

**3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв** ...................................................16

**3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг** ..........................................17

**3.8 Аудитын гол асуудал** .....................................................................................17

**3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**.........18

**3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт** .......................................................18

**3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт** ......................................................................19

**3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал** ...........................................................19

4. Аудитын илрүүлэлт .....................................................................................................19

4.1 Залруулсан алдаа ................................................................................................ 19

4.2 Албан шаардлага ................................................................................................ 19

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл..................................................................20

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ЕБС | Ерөнхий боловсролын сургууль |

АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
65130 Цэцэрлэг, Архангай аймаг
Утас/Факс:976-70333141
И-мэйл: arkhangai@audit.gov.mn

2022.02.22 № 37
танай ____________ -ны № ____________ -т

ЭРДЭНЭБУЛГАН СУМЫН ЛАБОРАТОРИ
НЭГДҮГЭЭР СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
Ж.ЭРДЭНЭЦЭЦЭГ ТАНАА

Аудитын санал дүгнэлт

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Архангай аймгийн Эрдэнэбулган сумын Лаборатори нэг дүгээр сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Эрдэнэбулган сумын Лаборатори нэг дүгээр сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Т.БАЙГАЛМАА

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

*2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* *\/ төгрөг/*

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **391,404,017.36** | **409,232,151.01** |
| 33 | АВЛАГА | 27,976,000.00 | - |
| 335 | Бусад авлага | 27,976,000.00 | - |
| 3352 | Хувь хүмүүсээс авах авлага | 27,976,000.00 | - |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **363,428,017.36** | **409,232,151.01** |
| 351 | Түүхий эд материал | 42,056,939.00 | 44,049,349.00 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 40,988,859.00 | 40,988,859.00 |
| 35130 | Эм боох материал | 1,068,080.00 | 3,060,490.00 |
| 354 | Хангамжийн материал | 308,181,078.36 | 349,882,802.01 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 3,781,590.00 | 5,938,195.45 |
| 35420 | Аж ахуйн материал | 273,282,868.36 | 303,482,146.56 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 223,760.00 | - |
| 35450 | Барилгын засварын материал | 30,892,860.00 | 40,462,460.00 |
| 35600 | Мал амьтад | 13,190,000.00 | 15,300,000.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **3,468,819,544.24** | **7,110,375,275.48** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **3,468,819,544.24** | **7,110,375,275.48** |
| 392 | Биет хөрөнгө | 3,074,351,419.24 | 6,715,078,805.48 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 2,653,391,104.84 | 6,196,412,244.84 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | - 106,291,502.40 | - 174,199,841.70 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 100,100,091.00 | 100,100,091.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | - 9,731,953.28 | - 26,415,301.76 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 599,828,324.26 | 469,461,875.50 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | - 434,473,986.72 | - 187,393,992.07 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 284,688,726.63 | 317,480,404.04 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | - 126,919,255.99 | - 120,074,540.97 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 260,238,203.00 | 66,047,235.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | - 225,509,277.20 | - 5,788,154.40 |
| 39217 | Ном | 79,030,945.10 | 79,448,786.00 |
| 393 | Биет бус хөрөнгө | 394,468,125.00 | 395,296,470.00 |
| 39301 | Програм хангамж | 2,709,650.00 | 2,375,220.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | - 1,781,525.00 | - 618,750.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 393,540,000.00 | 393,540,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **3,860,223,561.60** | **7,519,607,426.49** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **-** | **111,846,543.90** |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | - | 111,846,543.90 |
| 413 | Өглөг | - | 111,846,543.90 |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | - | 111,846,543.90 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **3,860,223,561.60** | **7,407,760,882.59** |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 3,860,223,561.60 | 7,407,760,882.59 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 1,838,224,779.81 | 1,838,224,779.81 |
| 51101 | Өмч: - төрийн | 1,838,224,779.81 | 1,838,224,779.81 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | - 593,838,399.30 | 2,953,698,921.69 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | - 593,838,399.30 | - 593,838,399.30 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | 3,547,537,320.99 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 2,615,837,181.09 | 2,615,837,181.09 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **3,860,223,561.60** | **7,519,607,426.49** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

*2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон / төгрөг/*

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **3,349,337,130.28** | **6,867,525,478.03** |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 329,449,730.28 | 3,792,556,392.58 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 329,449,730.28 | 3,792,556,392.58 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 329,449,730.28 | 3,792,556,392.58 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 86,561,000.00 | - |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 145,000.00 | - |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 242,743,730.28 | 3,792,556,392.58 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **3,019,887,400.00** | **3,074,969,085.45** |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 2,539,767,700.00 | 2,470,940,700.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 2,539,767,700.00 | 2,470,940,700.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 21,337,200.00 | 89,043,385.45 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 1,000,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 10,050,000.00 | 28,977,885.45 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 11,287,200.00 | 59,065,500.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 458,782,500.00 | 514,985,000.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 458,782,500.00 | 514,985,000.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **3,120,764,811.85** | **3,306,764,807.54** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **3,120,764,811.85** | **3,306,764,807.54** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **2,973,483,531.85** | **3,248,088,763.54** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **2,030,668,374.27** | **2,076,164,573.00** |
| 210101 | Үндсэн цалин | 1,146,995,982.27 | 1,214,645,732.00 |
| 210102 | Нэмэгдэл | 755,044,653.00 | 709,392,734.00 |
| 210104 | Урамшуулал | 128,627,739.00 | 152,126,107.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 254,049,324.73 | 270,190,427.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 173,654,024.73 | 189,050,702.68 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 20,098,800.00 | 20,676,275.97 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 16,079,000.00 | 16,463,740.85 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 4,019,800.00 | 4,003,756.51 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 40,197,700.00 | 39,995,950.99 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **444,071,576.00** | **601,331,143.90** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 10,686,616.00 | 12,696,450.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210302 | Түлш, халаалт | 294,645,660.00 | 385,442,496.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 138,739,300.00 | 203,192,197.90 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **22,344,100.00** | **45,876,450.80** |
| 210401 | Бичиг хэрэг | 4,129,700.00 | 5,014,230.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 823,380.00 | 3,423,760.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,302,000.00 | 1,072,010.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 2,404,000.00 | 2,424,800.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 5,695,020.00 | 6,854,864.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 7,990,000.00 | 27,086,786.80 |
| **2105** | **Нормативт зардал** | **30,900,905.00** | **47,393,736.00** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 2,690,590.00 | 5,672,790.00 |
| 210502 | Хоол, хүнс | 28,210,315.00 | 41,720,946.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **9,428,000.00** | **17,730,800.00** |
| 210604 | Урсгал засвар | 9,428,000.00 | 17,730,800.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **426,000.00** | **5,810,300.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 426,000.00 | 5,810,300.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **11,698,800.00** | **6,831,900.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 10,998,800.00 | 6,031,900.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 700,000.00 | 800,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **169,896,451.85** | **176,759,432.84** |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 11,298,350.00 | 7,372,660.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 158,598,101.85 | 169,386,772.84 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **147,281,280.00** | **58,676,044.00** |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 47,387,340.00 | 56,194,394.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 43,997,340.00 | 52,073,394.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 3,390,000.00 | 4,121,000.00 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 9,590,924.00 | - |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 9,590,924.00 | - |
| 2135 | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг | 90,303,016.00 | 2,481,650.00 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 90,303,016.00 | 2,481,650.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **228,572,318.43** | **3,560,760,670.49** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | **-** | **13,223,349.50** |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | - | 13,223,349.50 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | **-** | **- 13,223,349.50** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **228,572,318.43** | **3,547,537,320.99** |

**2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

*2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* */ төгрөг/*

| Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|
| **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **1,838,224,779.81** | **2,615,837,181.09** | **- 811,578,517.73** | **3,642,483,443.17** |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 1,838,224,779.81 | 2,615,837,181.09 | - 811,578,517.73 | 3,642,483,443.17 |
| Тайлант үеийн үр дүн | - | - | 217,740,118.43 | 217,740,118.43 |
| 2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 1,838,224,779.81 | 2,615,837,181.09 | - 593,838,399.30 | 3,860,223,561.60 |
| **2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **1,838,224,779.81** | **2,615,837,181.09** | **- 593,838,399.30** | **3,860,223,561.60** |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 1,838,224,779.81 | 2,615,837,181.09 | - 593,838,399.30 | 3,860,223,561.60 |
| Тайлант үеийн үр дүн | - | - | 3,547,537,320.99 | 3,547,537,320.99 |
| **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **1,838,224,779.81** | **2,615,837,181.09** | **2,953,698,921.69** | **7,407,760,882.59** |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

*2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон / төгрөг/*

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **3,078,617,400.00** | **3,102,945,085.45** |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 58,730,000.00 | 27,000,000.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 58,730,000.00 | 27,000,000.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 58,730,000.00 | 27,000,000.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 58,585,000.00 | 27,000,000.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 145,000.00 | - |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **3,019,887,400.00** | **3,075,945,085.45** |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 2,539,767,700.00 | 2,470,940,700.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 2,539,767,700.00 | 2,470,940,700.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 21,337,200.00 | 90,019,385.45 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 1,000,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 10,050,000.00 | 28,977,885.45 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 11,287,200.00 | 60,041,500.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 458,782,500.00 | 514,985,000.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 458,782,500.00 | 514,985,000.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **3,015,573,520.00** | **3,046,440,095.45** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **3,015,573,520.00** | **3,046,440,095.45** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **2,868,478,910.00** | **2,987,764,051.45** |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 2,030,057,192.00 | 2,076,161,950.00 |
| 210101 | Үндсэн цалин | 1,146,384,800.00 | 1,176,491,824.00 |
| 210102 | Нэмэгдэл | 755,044,653.00 | 739,820,626.00 |
| 210104 | Урамшуулал | 128,627,739.00 | 159,849,500.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **254,660,507.00** | **270,193,050.00** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 174,265,207.00 | 202,298,650.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 20,098,800.00 | 16,973,600.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 16,079,000.00 | 13,578,900.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 4,019,800.00 | 3,394,800.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 40,197,700.00 | 33,947,100.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **444,071,576.00** | **489,484,600.00** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 10,686,616.00 | 12,696,450.00 |
| 210302 | Түлш, халаалт | 294,645,660.00 | 328,649,800.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 138,739,300.00 | 148,138,350.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **19,867,100.00** | **32,643,295.45** |
| 210401 | Бичиг хэрэг | 4,129,700.00 | 5,017,785.45 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,000,000.00 | 3,200,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,801,500.00 | 1,072,010.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 3,141,500.00 | 2,424,800.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 9,794,400.00 | 20,928,700.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **42,451,615.00** | **53,536,246.00** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 6,210,800.00 | 7,887,700.00 |
| 210502 | Хоол, хүнс | 27,232,315.00 | 41,720,946.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 9,008,500.00 | 3,927,600.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **9,620,000.00** | **28,520,400.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | - | 1,220,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 9,620,000.00 | 27,300,400.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 426,000.00 | 5,810,300.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 426,000.00 | 5,810,300.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **15,945,100.00** | **7,149,100.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 15,245,100.00 | 6,349,100.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 700,000.00 | 800,000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 51,379,820.00 | 24,265,110.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 51,379,820.00 | 24,265,110.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **147,094,610.00** | **58,676,044.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **47,200,670.00** | **56,194,394.00** |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 43,810,670.00 | 52,073,394.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 3,390,000.00 | 4,121,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | **9,590,924.00** | **-** |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 9,590,924.00 | - |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **90,303,016.00** | **2,481,650.00** |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 90,303,016.00 | 2,481,650.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **63,043,880.00** | **56,504,990.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **52,211,680.00** | **56,504,990.00** |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 52,211,680.00 | 56,504,990.00 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 52,211,680.00 | 56,504,990.00 |
| 223001 | Бусад хөрөнгө | 52,211,680.00 | - |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | - | 56,504,990.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **- 52,211,680.00** | **-56,504,990.00** |
| 8 | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7) | 10,832,200.00 | - |
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | - |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **-** | **-** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

*2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон / төгрөг/*

| Дансны код | Үзүүлэлт | Тайлант оны | | Зөрүү | |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Дүн | хувь |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **3,015,925,700.00** | **3,010,444,050.00** | **5,481,650.00** | **99.82** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 3,015,925,700.00 | 3,010,444,050.00 | 5,481,650.00 | 99.82 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **2,958,367,500.00** | **2,954,249,656.00** | **4,117,844.00** | **99.86** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **2,056,481,200.00** | **2,056,481,200.00** | **-** | **100.00** |
| 210101 | Үндсэн цалин | 1,293,797,600.00 | 1,156,811,074.00 | 136,986,526.00 | 89.41 |
| 210102 | Нэмэгдэл | 602,834,100.00 | 739,820,626.00 | -136,986,526.00 | 122.72 |
| 210104 | Урамшуулал | 159,849,500.00 | 159,849,500.00 | - | 100.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **267,732,800.00** | **267,732,800.00** | **-** | **100.00** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 205,246,200.00 | 199,838,400.00 | 5,407,800.00 | 97.37 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 15,621,600.00 | 16,973,600.00 | -1,352,000.00 | 108.65 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 12,497,300.00 | 13,578,900.00 | -1,081,600.00 | 108.65 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 3,124,400.00 | 3,394,800.00 | -270,400.00 | 108.65 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 31,243,300.00 | 33,947,100.00 | -2,703,800.00 | 108.65 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **489,484,600.00** | **489,484,600.00** | **-** | **100.00** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 19,773,400.00 | 12,696,450.00 | 7,076,950.00 | 64.21 |
| 210302 | Түлш, халаалт | 328,649,800.00 | 328,649,800.00 | - | 100.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 141,061,400.00 | 148,138,350.00 | -7,076,950.00 | 105.02 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **29,538,700.00** | **29,470,910.00** | **67,790.00** | **99.77** |
| 210401 | Бичиг хэрэг | 3,278,900.00 | 3,278,900.00 | - | 100.00 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,000,000.00 | 2,000,000.00 | - | 100.00 |
| **210403** | **Шуудан, холбоо, интернэтийн төлбөр** | **1,139,800.00** | **1,072,010.00** | **67,790.00** | **94.05** |
| 210404 | Ном, хэвлэл | 8,165,000.00 | 8,165,000.00 | - | 100.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,929,800.00 | 1,929,800.00 | - | 100.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 13,025,200.00 | 13,025,200.00 | - | 100.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **63,085,400.00** | **59,036,246.00** | **4,049,154.00** | **93.58** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 13,387,700.00 | 13,387,700.00 | - | 100.00 |
| **210502** | **Хоол, хүнс** | **45,770,100.00** | **41,720,946.00** | **4,049,154.00** | **91.15** |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 3,927,600.00 | 3,927,600.00 | - | 100.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **25,500,400.00** | **25,500,400.00** | **-** | **100.00** |
| 210604 | Урсгал засвар | 25,500,400.00 | 25,500,400.00 | - | 100.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **360,300.00** | **360,300.00** | **-** | **100.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 360,300.00 | 360,300.00 | - | 100.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **7,115,000.00** | **7,114,100.00** | **900.00** | **99.99** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 6,315,000.00 | 6,314,100.00 | 900.00 | 99.99 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 800,000.00 | 800,000.00 | - | 100.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **19,069,100.00** | **19,069,100.00** | **-** | **100.00** |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 19,069,100.00 | 19,069,100.00 | - | 100.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **57,558,200.00** | **56,194,394.00** | **1,363,806.00** | **97.63** |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 57,558,200.00 | 56,194,394.00 | 1,363,806.00 | 97.63 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 53,437,200.00 | 52,073,394.00 | 1,363,806.00 | 97.45 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 4,121,000.00 | 4,121,000.00 | - | 100.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **3,015,925,700.00** | **3,010,444,050.00** | **5,481,650.00** | **99.82** |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **2,470,940,700.00** | **2,468,459,050.00** | **2,481,650.00** | **99.90** |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 2,470,940,700.00 | 2,468,459,050.00 | 2,481,650.00 | 99.90 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **514,985,000.00** | **514,985,000.00** | **-** | **100.00** |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 514,985,000.00 | 514,985,000.00 | - | 100.00 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | **30,000,000.00** | **27,000,000.00** | **3,000,000.00** | **90.00** |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 27,000,000.00 | 27,000,000.00 | - | 100.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 3,000,000.00 | - | 3,000,000.00 | |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | **1** | **1** | **-** | **100.00** |
| 610001 | Төсвийн байгууллага | 1 | 1 | - | 100.00 |
| **62** | **АЖИЛЛАГСДЫН ТОО** | **145** | **145** | **-** | **100.00** |
| 620001 | Удирдах ажилтан | 4 | 4 | - | 100.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 102 | 102 | - | 100.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 39 | 39 | - | 100.00 |
| **63** | **СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)** | **1** | **1** | **-** | **100.00** |
| **630** | **ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД** | **1** | **1** | **-** | **100.00** |
| ,630001 | Төрийн өмчит ЕБС | 1 | 1 | - | 100.00 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

*2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* */ төгрөг/*

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **10,505,000.00** | **59,659,385.45** |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 10,505,000.00 | 59,659,385.45 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 10,505,000.00 | 59,659,385.45 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | | 19,680,750.00 |
| 210101 | Үндсэн цалин | | 19,680,750.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | | **2,460,250.00** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | | 2,460,250.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **605,000.0** | **11,337,385.45** |
| 210401 | Бичиг хэрэг | 605,000.00 | 1,738,885.45 |
| 210402 | Тээвэр, шатахуун | | 1,200,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | | 495,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | | 7,903,500.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | | **3,020,000.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | | 1,220,000.00 |
| 210604 | Урсгал засвар | | 1,800,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | | **5,450,000.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | | 5,450,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | | **35,000.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | | 35,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 9,900,000.00 | **17,676,000.00** |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 9,900,000.00 | 17,676,000.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **10,505,000.00** | 90,019,385.45 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **10,505,000.00** | **90,019,385.45** |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 1,000,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 10,050,000.00 | 28,977,885.45 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 455,000.00 | 60,041,500.00 |
| **IV** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | - |
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | **-** |

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Архангай аймгийн Эрдэнэбулган сумын Лаборатори нэгдүгээр сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагын санхүү, нягтлан бодох бүртгэл, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, шилэн дансны хууль, 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын хэрэгжилттэй холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Гэрэлт хөхийн тэнцвэр аудит ХХК-ийн аудитор Л.Амарзаяа, аудиторын туслах Ц.Аюушжав нар гүйцэтгэж, чанарын хяналтыг менежер Ж.Ням-Осор, Захирал Д.Баатарсайхан нар тус тус хэрэгжүүлсэн.

Эрдэнэбулган сумын Лаборатори нэг дүгээр сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Гэрэлт хөхийн тэнцвэр аудит ХХК-д 2022 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 07 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Архангай аймаг Эрдэнэбулган сумын Лаборатори нэгдүгээр сургуулийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Хичээл сургалтын үйл ажиллагааг эрүүл аюулгүй байдал, халдвар хамгааллын дэглэмд нийцүүлэн танхимын болон цахим хэлбэрээр тасралтгүй, чанартай зохион явуулж, суралцагчийг сурлагаар хоцрогдох, хичээл завсардахаас сэргийлэн, сэтгэл зүйн дэмжлэг үзүүлж, багш өөрийн мэргэжлээр тасралтгүй хөгжих боломжийг бүрдүүлэх.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналт шалгалтын жилийн ажлын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу хичээл сургалт, хичээлээс гадуурх үйл ажиллагаа, хөдөлмөрийн сахилга бат, хууль тогтоомжийн хэрэгжилт, санхүү аж ахуйн үйл ажиллагааны өнөөгийн байдалд хяналт шалгалт хийж ажилсан байна. Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Лаборатори нэг дүгээр сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлсөн, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу тухайн жилийн төсвийн орлого, зарлагын гүйцэтгэл, хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүн, нэмэлт төсвийн гүйцэтгэлийг бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр “Батлагдсан төсөв”-ийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсөв 3,015.9 сая төгрөгөөс 1 хувиар буюу 30.2 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 22.6 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг хянаж үзээд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Лаборатори нэгдүгээр сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 3,659.4 сая төгрөгөөр буюу 195 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь үндсэн хөрөнгийн дансанд гарсан өөрчлөлт байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /сая төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Авлага | 28.0 | 0.0 | -28.0 |
| Бараа материал | 363.4 | 409.2 | 45.8 |
| Үндсэн хөрөнгө | 3468.8 | 7110.4 | 3641.6 |
| **Нийт хөрөнгө** | **3860.2** | **7519.6** | **3659.4** |
| Өр төлбөр | 0.0 | 111.8 | 111.8 |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 3860.2 | 7407.8 | 3547.5 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **3860.2** | **7519.6** | **3659.4** |

Дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Бараа материалын үлдэгдэл өмнөх оноос 12.6 хувиар өссөн байна.

Бараа материалын данс нь 363.4 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 183.9 сая төгрөг, бусад байгууллагаас үнэ төлбөргүй хүлээн авсан 12.7 сая төгрөгөөр тус тус нэмэгдэж, тайлант онд 163.0 сая төгрөгөөр хасагдаж, эцсийн үлдэгдэл 409.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

- Үндсэн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оноос 105.0 хувиар өссөн байна.

Үндсэн хөрөнгө данс нь 3,468.8 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдаж авсан 56.5 сая төгрөг, үнэ төлбөргүй хүлээн авсан 3,656.6 сая төгрөг, үндсэн хөрөнгө дахин үнэлж нэмсэнтэй холбоотой 111.0 сая төгрөгөөр тус тус нэмэгдэж, 163.3 сая төгрөгийн хөрөнгө акталсан, үндсэн хөрөнгийн дахин үнэлэхтэй холбоотойгоор данснаас 409.6 сая төгрөгийн хөрөнгө хассан, тайлант хугацааны элэгдэл 169.4 сая төгрөгөөр, үндсэн хөрөнгийн дахин үнэлэхтэй холбоотойгоор данснаас хассан элэгдэл 559.6 сая төгрөг болж 7,110.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

- Өр төлбөр данс нь 111.8 сая төгрөгөөр өссөн ба энэ нь сургуулийн өргөтгөлийн барилга ашиглалтад орсонтой холбоотойгоор дулаан, цахилгааны өглөг нэмэгдэж үүссэн байна.
- Цэвэр хөрөнгө өмчийн дүн 3,547.5 сая төгрөгөөр өссөн нь тайлант хугацаанд үнэ төлбөргүй авсан үндсэн хөрөнгө нөлөөлсөнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Санхүүгийн үр дүнгийн тайлангийн үзүүлэлт

/сая төгрөг/

| Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1.0 | 2.0 | 3=2-1 |
| Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 2,539.8 | 2470.9 | - 68.8 |
| Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 458.8 | 515.0 | 56.2 |
| Үндсэн үйл ажиллагааны орлого | 86.7 | 0.0 | - 86.7 |
| Нэмэлт санхүүжилтийн орлого | 21.3 | 89.0 | 67.7 |
| Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 160.1 | 3767.7 | 3,607.5 |
| Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | 82.6 | 24.9 | - 57.7 |
| **Үйл ажиллагааны орлого** | **3,349.3** | **6867.5** | **3,518.2** |
| Цалин, шимтгэлийн зардал | 2,284.7 | 2346.4 | 61.6 |
| Бараа үйлчилгээний зардал | 507.2 | 718.1 | 211.0 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 11.7 | 6.8 | - 4.9 |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 169.9 | 176.8 | 6.9 |
| Урсгал шилжүүлэг | 147.3 | 58.7 | - 88.6 |
| Хөрөнгө шилжүүлсэн | - | 0.0 | - |
| Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | - | 13.2 | 13.2 |
| **Үйл ажиллагааны зардал** | **3,120.8** | **3320.0** | **199.2** |
| **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)** | **228.6** | **3547.5** | **3,319.0** |

Тус сургуулийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн урсгал үйл ажиллагааны санхүүжилтийн орлого өмнөх оноос 56.2 сая төгрөг буюу 12.25 хувиар өссөн нь сургуулийн өргөтгөл баригдаж ашиглалтад орсонтой холбоотой санхүүжилт өссөн байна. Төлөвлөсөн санхүүжилтийг зарцуулж ажилласан байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зарлагыг 3,015.9 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсөв захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг нийт 3,015.9 сая төгрөгөөр хянаж баталсан байна.

### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд 3,015.9 сая төгрөгийн төсөв батлагснаас гүйцэтгэлээр улсын төсвөөс 3,015.9 сая төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 3,010.4 сая төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 6,010.4 сая төгрөг буюу 99.8 хувьтай байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтээр 90.0 сая төгрөгийн орлого бүрдүүлж төсөвт төвлөрүүлсэн байна
Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

## 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тус сургууль нь тайлант онд 3,543.0 сая төгрөгийн сургуулийн өргөтгөлийн барилга үнэ төлбөргүйгээр шилжүүлэн авч ажилласан нь цэвэр бохир ус, түлш халаалтын өр 111.8 сая төгрөгөөр өсөхөд нөлөө үзүүлсэн байна.

Мөн 2021 онд тус байгууллага нь “Ковид-19” цар тахлаас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, бэлэн байдлыг хангах, хичээл сургалтын үйл ажиллагааны явцад халдвараас сэргийлэх дэглэмийг сахиулахтай холбоотой сургууль орчмын бүс, сургалтын байр анги танхимд 2 цаг тутам цэвэрлэгээ, 5 хоногт 1 удаа ариутгал хийж ажилласан байна.

Архангай аймгийн орон нутгийн өмчийн газрын зөвшөөрлөөр 56.5 сая төгрөгийн үнэ бүхий тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, номыг төсвийн хөрөнгөөр худалдан авсан нь Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолыг хэрэгжүүлээгүй байна.

## 3.8 Аудитын гол асуудал

Материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ гараагүй байна.

Тус байгууллага нь 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан стратегийн зорилтуудыг хангахад чиглэсэн 4 үндсэн зорилтын хүрээнд 35 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлээр дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилт 91.5 хувь байна.

Тайлант онд хэрэгжүүлэх 1 хөтөлбөр, 5 арга хэмжээнд зориулан нийт 3,015.9 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр нийт 3,010.4 сая төгрөгийг зарцуулсан бөгөөд төсвийн гүйцэтгэл 99.8 хувь байна.

Тус байгууллага нь өөрийн орлогыг 27.0 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 59.0 сая төгрөгийг төвлөрүүлж орлогын төлөвлөгөөг 218.7 хувиар давуулан биелүүлжээ. Энэ нь сурагчдын сургалтын төлбөрийн орлого бөгөөд үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөг бодитой бус төлөвлөсөн байна.

Аудитын явцад санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн дагуу дараах судалгааг авч үнэллээ. Үүнд:

1.Төсвийн хэмнэлтийн талаар авсан арга хэмжээ, түүний үр дүн судалгааг авч үзэхэд батлагдсан төсвийн хүрээнд зардлыг зарцуулсан байна. Үүнд:

Тус сургууль өндөр насны тэтгэвэрт тогтоолгож чөлөөлөгдсөн 1 ажилтны орон тоон дээр нөхөн томилгоо хийсэн байна.

Албан томилолт, бичиг хэрэг, тогтмол зардлуудыг батлагдсан төсвийн хүрээнд зарцуулсан байна.

2.Суудлын автомашин ашиглалтын хувьд: MMI-800B маркийн 0823 АРА улсын дугаартай 2018 онд үйлдвэрлэгдсэн 100.1 сая төгрөгийн анхны өртөг бүхий автомашинтай бөгөөд шатахууны зардалд 3.4 сая төгрөгийг зарцуулсан, орон тооны жолоочгүй байна.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгаж үр дүнг баримтжуулсан /Local.audit.mn сайтад шивсэн/, Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай ЗГ-ын 43-р тогтоолын хэрэгжилтийг судалгаагаар шалгаж баримтжууллаа.

### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус сургууль нь тайлант хугацаанд шилэн дансанд оруулбал зохих 142 мэдээллээс 140 мэдээллийг хугацаанд нь, 2 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан байна.

***<u>Шийдвэрлэсэн нь</u>*:** Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 дахь заалтыг хэрэгжүүлж, мэдээллийг хуульд заасан хугацаанд тогтмол мэдээлж хэвших гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй тул зөвлөмж хүргүүлэв.

### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд дараах зөрчлүүд илрэв. Үүнд:

1. Тайлангийн жилд тус сургуулийн дуу хөгжмийн багш Н.Энхжаргал нь 2021 оны 6 дугаар сарын 02-ны өдөр захирлын Б/35 тоот тушаалаар өндөр насны тэтгэвэрт гарсан бөгөөд түүний орон тоон дээр О.Мөнхзаяаг захирлын 2021 оны 9 дүгээр сарын 01-ны өдрийн Б/58 тушаалаар ажилд томилон нийт 4.6 сая төгрөгийн цалингийн зардал гаргасан байна.

   ***<u>Шийдвэрлэсэн нь</u>*:** Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.2-д Шинээр ажлын чиг үүрэг, албан тушаал бий болгохгүй, орон тоог нэмэгдүүлэхгүй байх, өндөр насны тэтгэвэр тогтоолгож чөлөөлөгдсөн ажилтан, албан тушаалтны орон тоог царцааж, нөхөн томилгоо хийхгүйгээр цалингийн зардлыг хэмнэх гэснийг хэрэгжүүлээгүй 4.6 сая төгрөгийн зардал гаргасан тул албан шаардлага хүргүүлж байна.

2. Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолд "Батлагдсан төсөвт зардлын дүнд 10-с доошгүй хувийн хэмнэлт гаргаж ажиллах" гэсэн заалтын хүрээнд төсвийн хасагдах тохируулга хийснээр тус байгууллага нь 634.2 сая төгрөгийг зарцуулахаас гүйцэтгэлээр 630.0 сая төгрөгийн зардал гаргасан байна. Тогтоолын хүрээнд 63.4 сая төгрөгийн хэмнэлт гаргахаас 4.1 сая төгрөгийн хэмнэлт гаргаж, 59.3 сая төгрөгийн хэмнэлт гаргаагүй байна.

***Шийдвэрлэсэн нь*:** Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолд "Батлагдсан төсөвт зардлын дүнд 10-с доошгүй хувийн хэмнэлт гаргаж ажиллах" гэсэн заалтыг мөрдөж ажиллаагүй 59.3 сая төгрөгийн хэмнэлт гаргаагүй тул албан шаардлага хүргүүлэв.

3.Тус байгууллага нь тогтмол зардалд /гэрэл цахилгаан, түлш халаалт, цэвэр бохир ус/ 489.5 сая төгрөг батлуулж, гүйцэтгэлээр 489.5 сая төгрөгийн зардал гаргаж, 97.9 сая төгрөгийн хэмнэлт гаргаагүй ажилласан байна.

***Шийдвэрлэсэн нь*:** Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.8-д заасан тогтмол зардалд 20-ис доошгүй хувийн хэмнэлт гаргах гэсэн заалтыг мөрдөөгүйд албан шаардлага хүргүүлэв.

Шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-д заасан “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх” гэсэн заалттай нийцээгүй, бусад хууль тогтоомжийн хүрээнд Монгол Улсын Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын 1.1-д заасан үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10 хувиас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах” гэсэн заалтай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Нийт 88.3 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 57.6 сая төгрөгийн алдааг залруулж, 30.8 сая төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 4 зөвлөмж хүргүүлсэн ба зөвлөмжийн биелэлт бүрэн хэрэгжсэн байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар үндсэн үйл ажиллагааны орлого бүрдүүлэлт, түүний зарцуулалтыг шалгана.

## 4. Аудитын илрүүлэлт

Санхүүгийн тайлангийн аудитын шалгалтаар нийт 3.4 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснийг залруулсан тул зөрчлийг арилгах албан шаардлага, зөвлөмж хүргүүлээгүй болно.

Аудитаар залруулагдаагүй алдаа зөрчил илрээгүй тул Зөрчилгүй дүгнэлт өглөө.

### 4.1 Залруулсан алдаа

- Цалингийн өглөг дансны бүртгэлийг 3.4 сая төгрөгөөр зөрүүтэй, алдаатай бүртгэсэн.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн 14-р зүйл, Сангийн сайдын 2006 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн 388 дугаар тушаалаар батлагдсан "Нягтлан бодох бүртгэлийн заавар" тай нийцэхгүй байна.

***Шийдвэрлэсэн нь*:** Байгууллагын удирдлага, нягтлан бодогч нарт асуудлын бүртгэлээр танилцуулан 3.4 сая төгрөгийн залруулга хийж, залруулсан тухай 2022 оны 2 дугаар сарын 14-ний өдрийн №13 албан тоот ирүүлж санхүүгийн тайланд залруулга хийсэн болно.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Санхүүгийн тайлангийн аудитын асуудал | | | | | | | | | | | |
| 1 | Ерөнхий боловсролын лаборатори Нэгдүгээр сургууль | 1 | 3.4 | 1 | 3.4 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Дүн | | 1 | 3.4 | 1 | 3.4 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Санхүүгийн тайлангийн аудитын шалгасан нийцлийн аудитын асуудал | | | | | | | | | | | |
| | Ерөнхий боловсролын лаборатори Нэгдүгээр сургууль | 4 | 161.8 | 0 | 0 | 0 | 0 | 3 | 161.8 | 0 | 0 |
| Дүн | | 4 | 161.8 | 0 | 0 | 0 | 0 | 3 | 161.8 | 1 | 0 |
| Нийт дүн | | 5 | 165.2 | 1 | 3.4 | 0 | 0 | 3 | 161.8 | 0 | 0 |